

**ӨВ. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,  
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭ  
/2021 оны 2 дугаар улирал/**

2021.06.22

Өвт

№	Ажлын чиглэл	Үзүүлэлт	Сум, байгууллага /тоон үзүүлэлт/	
1	Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо	13282	
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо	230	
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл, заалтын тоо	18/42	
		Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	250
			Байгууллага	6
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	20
Байгууллага	4			
2	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж /гарсан захирамж/	Нийт 110 захирамж	
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүйн яаманд хянуулж бүртгүүлсэн	-
			Хууль зүйн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг	12	
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо	250	
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа	38	
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал	17 сэдвээр 4200ш	
		Радио, телевизийн нэвтрүүлэг	-	
		Сонин хэвлэлээр сурталчилсан	-	
		Бусад /Цахим хуудас, Facebook/ хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан	22 сэдвээр 20000 гаруй иргэнд хүрсэн	

МЭДЭЭ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ХЭЗ МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ИЛТГЭХ ХУУДАС  
/2021 оны 2 дугаар улирал/**

2021 оны 06 дугаар сарын 22

Өвт

Дэлхийн улс орнуудад шинэ төрлийн коронавируст халдвар эрчимтэй тархаж, Монгол Улсад тээвэрлэгдэн ирж, өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байгаатай холбогдуулан сумын Онцгой комиссоос Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын тогтоол, хурлын тэмдэглэл, аймаг, сумын Засаг даргын шийдвэрийг мөрдөж, сумын иргэдэд цахим болон гарын авлагаар эрх зүйн сургалт, сурталчилан таниулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. 2021 оны хагас жилийн байдлаар Коронавируст халдвартай холбоотой сумын Засаг даргын 17 захирамж гарч хэрэгжүүлэн, шийдвэрийг тухай бүр сумын пэйж хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлж ажиллаа.

Тайлант хугацаанд хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр сумын хэмжээнд дараах ажлуудыг зохион байгуулж ажиллаа. Үүнд:

**Удирдлага зохион байгуулалт болон төрийн захиргааны байгууллагаас  
хэрэгжүүлсэн ажлын талаар**

Бат-Өлзий сумын “Эрх зүйн сургалт, сурталчилгааны баг”-ийн үйл ажиллагаа тогтмолжиж төлөвлөгөөний дагуу иргэдэд хууль тогтоомж, хуулинд орсон нэмэлт өөрчлөлт, танин мэдэхүйн чиглэлээр ажил хариуцсан албан хаагчид 1500-аад ширхэг гарын авлага тараах материал иргэдэд тарааж ажилласан. Үүний үр дүнд төрийн албан хаагчид болон иргэдийн хууль эрх зүйн зохих мэдлэг сайжирсан. Мөн Бүх нийтийн эрх зүйн боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд бэлтгэгдсэн эрх зүйн хөтөч нар сумын нэгдсэн грүпп, Бат-Өлзий сумын урьдчилан сэргийлэх грүппээр иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх хуулийн сурталчилгааг байнга түгээж, зөвлөгөө мэдээллийг өгч ажилладаг. Зөвлөгөө, мэдээлэлд 840 иргэн хамрагдсан.

Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам” 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийн дагуу Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг 2021 оны 03 сарын 25 -ны 16.00 цагт Соёлын төвийн урд талбайд жагсаан ирц бүртгэв. Мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд 8 албан хаагч пост болон хөдөлгөөнт эргүүлж ажиллаж байсан. Бусад бие бүрэлдэхүүн бүрэн цугларсан. Сумын ЗДТГ-ын дарга Н.Бат-Эрдэнэ Гамшгийн аюулын үед зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам болон гамшгийн үед газар хөдлөлт, нүүлгэн шилжүүлэх журам, цар тахлын үед иргэдэд зөвлөмж, мэдээлэл өгөх талаар цугларсан 65 иргэнд танилцуулга хийж, мэдээлэл өгөв.



2021 оны 04 дүгээр сарын 01-30-ны хооронд “Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлье” уриан дор Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулсан. Хүнсний дэлгүүрүүдэд хяналт тавьж халвараас сэргийлэх зөвлөмж тараасан. Аяны хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудын



шийдвэрүүдийг 1-р улиралд 36 иргэн, 2-р улиралд 37 иргэн нийт 73 иргэнд хүргэж зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилласан.

2021 оны 05 дугаар сард “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” зорилтот жилийн хүрээнд 150 ширхэг гарын авлага бэлтгэн малчин иргэдэд тарааж, зөвлөмж зөвлөгөө өгөв.



Замын хөдөлгөөний дүрмийн заалтыг тайлбарлан таниулсан гарын авлага бэлтгэн Цагдаагийн тасгийн Олон нийтийн цагдаагийн ажилтан, замын цагдаагийн зохицуулагч нар иргэдэд тарааж, шторк бичлэгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гүрпээр сурталчилсан. Нийт сурталчилгаанд 700 гаруй иргэн хамрагдсан. Замын хөдөлгөөнд оролцож зөрчил гаргасан 56 иргэнд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцсон.

“Хүүхдэд ээлтэй жолооч” аяны хүрээнд сумын ГХУСАЗСЗөвлөл, Цагдаагийн тасаг хамтран замын хөдөлгөөнд оролцож буй 200 иргэнийг тус аянд нэгдүүлж, сэрэмжлүүлэг, гарын авлага бэлтгэн нийт 400 ширхэгийг хийж тарааж, болзошгүй эрсдэлээс сэргийлж, замын хөдөлгөөний дүрэм журмыг мөрдүүлж ажиллаж байна.





Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг видео бичлэгийг сумын Facebook групп-ээр иргэдэд сурталчилсан. Нийт 3000 гаруй иргэн үзэж гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийн талаар ойлголт, мэдээлэлтэй болсон.

Интернет, гар утасны хор хөнөөлийг таниулсан сэрэмжлүүлэг, шторкийг Бат-Өлзий сумын нэгдсэн групп, урьдчилан сэргийлэх группээр иргэдэд сурталчилан таниулсан. Хандалтын тоо 4500-д хүрсэн.

Сумын Хамтарсан баг “Хүүхдийн чуулга уулзалт”-ыг 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдөр цахимаар зохион байгууллаа. Уулзалтанд Ерөхний боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн 112 сурагч, Сумын Засаг дарга С.Амгалан, ЕБС-ийн захирал Н.Орхонтуул,

нийгмийн бодлогын мэргэжилтэн Г.Цэрэндулам, ЕБС-ийн нийгмийн ажилтан Б.Бямбадорж, ЭМТөвийн нийгмийн ажилтан Г.Ганчимэд, хүүхдийн элч Г.Бямбагарав, хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудыг төлөөлөн бага ангийн багш А.Амартүвшин нар оролцлоо. Бусдыгаа төлөөлөн чуулганд оролцож байгаа хүүхдүүдээс тулгамдаж байгаа асуудлын талаар санал бодлыг сонсож, удирдлагуудын зүгээс хариулж авч, зарим асуудлыг шийдвэрлүүлж чадсан үр дүнтэй чуулган боллоо.

Чуулга уулзалт



Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шторк бичлэгийг Facebook-ээр нийтэлж, иргэдэд сурталчилсан. 2000 гаруй иргэн үзсэн.

Байгаль орчны журам зөрчсөн иргэн, аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулинд хэрхэн заасныг иргэдэд таниулан, сурталчилах ажлыг “Бат-Өлзий урьдчилан сэргийлэх ажил цахим хаяг, сумын нэгдсэн группээр нийтэлж түгээсэн.

Түймэрийн аюултай үеүүдэд буюу 2021 оны 3 дугаар сарын 05-наас 5 дугаар сарын 15-ны хооронд ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэдэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цахимаар болон цаасаар хүргэж, сурталчилсан. Сурталчилгаанд 2000 гаруй иргэн хамрагдсан. Мөн хөдөөгийн багийн 250 айл өрхөд ой, тал хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх, асаасан гал, нурам, цогоо бүрэн унтрааж байх санамж бичиг, сэрэмжлүүлэгийг хийж тараасан. Байгаль хамгаалах нөхөрлөлүүдээс түймэр гаргахгүй байх баталгаа гаргуулж, эргүүл, хяналтын ажлыг сайжруулах үүрэг даалгавар өгч хамтран ажиллаж байна.

2021 оны 4 дүгээр сард “Байгаль орчныг хамгаалах” сарын аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд 200 ширхэг боршур, гарын авлага тарааж, 1 удаа аж ахуйн нэгж, нөхөрлөлийн гишүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтад 300 гаруй иргэн хамрагдсан.

Боловсрол, соёлын салбарын чиглэлээр зохион байгуулсан сургалт, сурталчилгаа

2021 оны 3 дугаар сард Төрийн байгууллагуудын албан хаагчдад сумын Соёлын төвөөс “Угийн бичиг хөтлөх ач холбогдол, арга зүй” сургалтыг хэсэгчлэн зохион байгууллаа. Мөн байгууллагуудын групп чат-нд баршуулж, нийт 242 төрийн албан хаагч хамрагдлаа.



Төрийн байгууллагуудын албан хаагч 1 хүн 5 өрх сонгон өрхөд угийн бичиг хөтлүүлэх арга зүйн сургалтыг өрх тус бүр өгч, угийн бичиг хөтлөх заавар зөвлөгөө аргачлалтай боршуур тараасан. 1 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчид сонгосон 165 өрхөд цахим сургалтыг групп чатаар өгч, сумын Угийн бичиг хөтлөх группэд өрхийг нэмж оруулан цахимаар мэдээлэл солилцон идэвхи, санаачлагатай ажиллаж байна.



“Үндэсний бичиг III” хөтөлбөрийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, уран зохиолын 8 багш 5 байгууллагын 150 албан хаагчдад үндэсний бичгийн хичээл заасан. Хичээл сургалтаа эхлэхээс өмнө албан байгууллагуудад мэдээлж, хөтөлбөрийн зорилго чиглэлийг танилцуулан ажилчдаас унших, бичих чадвараар гараа тогтоож сургалтаа эхлэсэн. Үүнээс анхлан суралцагчдын гараа 30%-тай байсан. Судалгааг үндэслэн 2 бүлэгт хуваан 7 хоногт нэг нэг удаа хичээл орсон. Бүлэг 1: Унших бичих чадвар

сайн учир групп чат үүсгэж мэдээлэл болон уншиж, бичих даалгавар байршуулж, хүнд, гаргахгүй үгсээ асууж ярилцаж байв. Танхимаар орохдоо зөвхөн хичээнгүй бичиг заалгах сонирхолтой хүмүүс сууж, бичгийн хэвээ сайжруулах зорилгоор суралцлаа. Бүлэг 2: Анхлан суралцах шаардлагатай 45 хүнийг хамрууллаа. Эдгээр суралцагч нар 7 хоногийн 3 дахь өдөр бүр 17-19 цагийн хооронд хичээллээ.



СӨББайгууллагууд сургалтын хөтөлбөрийн агуулга боловсруулалт, хичээлийг 14 бүлгийн эцэг, эхчүүдэд цахимаар танилцуулж, теле хичээлийн хуваарийг мэдээлж, ардын уламжлалт ёс заншилаа мэдүүлэх сэдвийг бүлэг тус бүр 6 чиглэлийн дагуу хүүхдийн насанд тохирсон хичээлүүдийг өөр өөрийн бүлгийн эцэг, эхчүүдэд цахимаар мэдээлсэн.

Эрүүл мэндийн салбарын чиглэлээр болон Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

Цаг үеийн байдлаас шалтгаалж иргэн бүрт тухайн байгаа орчинд нь эрүүл мэндийн сургалт, мэдээллийг зохион байгуулсан.

ЭМТөвд хэвтэн эмчлүүлсэн нийт 214 иргэнд Коронавирусээс урьдчилан сэргийлэх, болон зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөн гэх мэт сэдвүүдээр тогтмол мэдээлэл өгч ажиллаж байна.

ЭМДаатгалаар үйлчлүүлэгч 2700 иргэнд эмийн зохистой хэрэглээ сэдвээр мэдээлэл өгч ажилласан.

1 улиралд цахим хуудсанд 65 удаагийн сэрэмжлүүлэг, зөвлөмж, мэдээлэл байршуулсан ба хандалтын тоо 105683. /Мэдээллийг сум болон ЭМТ-ийн цахим хуудсаар эмч мэргэжилтнүүд байршуулж байсан./ Нийт 2670 ширхэг зөвлөмж хийж, тараасан.

2 улиралд 56 удаагийн сэрэмжлүүлэг зөвлөмж цахим орчинд байршуулсан. Хандалтын тоо 111827. 2021 оны 01 сарын 17- ноос 06 сарын 17-ны өдөр хүртлэх хугацаанд нийт 1103 иргэнийг гэрийн ажиглалтанд хянаж, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллээр өдөр бүр хангаж ажиллаж байна. Эмч, ажилтнууд үүртийн постонд 2, 3, 5, 6 саруудад 24 цагаар тогтмол үүрэг гүйцэтгэж сумын төврүү нэвтэрсэн 10000 гаруй иргэн бүрт ковидын халдварын эсрэг мэдээлэл, зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.



Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг Бат-Өлзий сумын Урьдчилан сэргийлэх цахим сүлжээгээр иргэдэд түгээж ажилласан. Хандалт 1244 хүнд хүрсэн.


ЭМТөвөөс сумын төвийн 6 худгийн орчинд үнэлгээ хийж халтиргаа гулгаанаас сэргийлэх зорилгоор овойж хөлдвөсөн мөсийг 2 удаа цэвэрлүүлж, ус түгээгч нийт 5 хүнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн.



- ✓ 2021 оны 04 сарын 03 нд 1 тунгийн вакцин хийлгэсэн 243 хүнд дархлаажуулалтын дараах үеийн урвал хүндрэл, хариу урвалын талаар хүн нэг бүрт сургалт хийж, зөвлөгөө өгсөн.
- ✓ 05.03-ны өдрөөс 06 сарын 17-ны өдрийг хүртлэх хугацаанд давхцсан тоогоор нийт 7633 хүнд дархлаажуулалт болон короновирусын халдвараас сэргийлэх, гарын эрүүл ахуй сахиx талаар сургалт мэдээлэл хийсэн байна.



Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх гэрийн орчиндоо хэрхэн эрүүл ахуйг сахиx талаар 2 төрлийн зөвлөмж бэлтгэж нийт 500 ширхэгийг хэвлэж түгээсэн.



Эрүүл мэндийн газрын цахим хуудсанд байршуулсан мэдээлийг сумын эмнэлгийн цахим хуудас, сумын цахим хуудсанд байршуулж байна.



2021 оны 2 дугаар улиралд эрх, зүйн сургалт 12 удаа зохин байгуулж, сургалтанд нийт 250 хүн, эрх зүйн сурталчилгааг 38 удаа явуулж 17 сэдвээр 4200 гаруй зөвлөмж, гарын авлага, тараах материал иргэдэд тарааж ажилласан байна.

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ДОРЖХАНД

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН